



ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ  
КОРПОРАЦИ

**ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ, ДОТООД ХЯНАЛТЫН ГАЗАР  
ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ЗОХИЦУУЛАЛЫН ГАЗАР**

ТҮРЭЭСИЙН БОЛОН ТҮРЭЭСЛЭЭД ӨМЧЛӨХ  
ГЭРЭЭ БАЙГУУЛСАН 1520 ХУВИЙН ХЭРЭГТ  
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Улаанбаатар хот  
2025 он

## Агуулга

1. Танилцуулга
2. Хяналт шалгалтын зорилго, хамрах хүрээ
  - 2.1 Хяналт шалгалтын зорилго
  - 2.2 Хяналт шалгалтыг хамрах хүрээ, хязгаарлалт
  - 2.3 Хяналт шалгалт хийх арга, аргачлал
3. 1520 гэрээний танилцуулга
4. Хяналт шалгалтын талаар
  - 4.1 Мөрдөгдөж байгаа тогтоол, журам, тушаалын хүчинтэй, хүчингүй судалгаа
  - 4.2 Процессын зураглал
  - 4.3 Төрийн өмчийн түрээсийн орон сууцыг түрээслүүлэх, өмчлүүлэх ажлыг зохион байгуулсан ажлын талаар
  - 4.4 Албан бичгээр гэрээ цуцлах тухай болон мэдэгдэл хүргүүлсэн тухай
  - 4.5 Буянт Ухаа-2 хороолол
  - 4.6 Хангай хотхон
  - 4.7 Увс
  - 4.8 Ховд
  - 4.9 Хэнтий
  - 4.10 Архангай
  - 4.11 Дархан-Уул
  - 4.12 Сэлэнгэ
  - 4.13 Нийт гэрээний хэрэгжилт
  - 4.14 Авлагын үлдэгдэлтэй иргэдийн талаар
  - 4.15 Илэрсэн зөрчлийг арилгуулах талаар хууль, хяналтын байгууллагад хандсан талаар
5. Хяналт шалгалтын ажлын нэгдсэн дүгнэлт
6. Зөвлөмж
7. Төлбөрийн мэдээлэл нэмэгдүүлэх талаар

## 1. ТАНИЛЦУУЛГА

Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврын дагуу Хууль, эрх зүй, дотоод хяналтын газраас "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025 оны А/70 тушаалаар 1520 гэрээний хувийн хэрэгт "Хяналт шалгалт явуулах тухай" удирдамж, ажлын хэсгийг байгуулсан.

Засгийн газрын 2016 оны 38 дугаар тогтоолоор 929, 169 дүгээр тогтоолоор 360, 298 дугаар тогтоолоор 223, нийт 1512 орон сууц түрээсийн орон сууцны санд шилжиж ирсэн. "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн Захирлын зөвлөлийн хурлын шийдвэрээр борлогдоогүй үлдсэн орон сууцнуудаас 8-г түрээсийн зориулалтаар шилжүүлсэн. Үүний үр дүнд 1520 айлын орон сууцтай болсон.

Төрийн түрээсийн орон сууцыг түрээслүүлэх, түрээслээд өмчлөх гэрээ байгуулсан 1520 хувийн хэрэгт хяналт шалгалт хийсэн ажлын тайланг танилцуулж байна.

## 2. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ

### а. Хяналт шалгалтын зорилго:

"Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн үндсэн үйл ажиллагаа болох "Зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах" төсөл хөтөлбөрийн хүрээнд Төрийн өмчийн түрээсийн орон сууцыг түрээслүүлэх журам, түрээслээд өмчлөх журам, сонгон шалгаруулалт явуулж байгаа арга хэлбэр, гэрээ нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж байгаа эсэхэд хяналт тавих, удирдлагыг мэдээллээр хангахад оршино.

### б. Хяналт шалгалтын хамрах хүрээ, хязгаарлалт

"Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ийн төрийн өмчийн түрээсийн орон сууцны хувийн хэрэг, сонгон шалгаруулалт зарласан эсэх, түрээслүүлэх, түрээслээд өмчлүүлэх гэрээнд хяналт шалгалт хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Нийслэлд Буянт Ухаа-2 хороолол, Хангай хотхоны төрийн өмчийн түрээсийн орон сууцад иргэдийг сонгон шалгаруулж хамруулсан эсэх,
- Орон нутагт төрийн өмчийн түрээсийн орон сууцад иргэдийг сонгон шалгаруулж хамруулсан эсэх
- Түрээслүүлэх, түрээслээд өмчлүүлэх ажлыг зохион байгуулахдаа гэрээ дүгнэсэн, батлагдсан журам баримтласан эсэх
- Түрээслүүлэх, түрээслээд өмчлүүлэх ажлыг зохион байгуулахдаа, журам баримтласан, гэрээ дүгнэсэн эсэхэд хяналт тавих зорилгоор гэрээ болон хувийн хэрэгт шалгалт хийлээ.

Хяналт шалгалтын удирдамжийн дагуу ажлын хэсэг нотолгоо цуглуулж, дүгнэлтээ гаргасан болно.

Хяналт шалгалтын хүрээнд дараах эрх зүйн баримт бичгүүдийг үндэслэн:

- Засгийн газрын 2015.06.15-ны өдрийн "Түрээсийн орон сууц батлах тухай" 248 дугаар тогтоол
- Засгийн газрын 2016.01.11-ны өдрийн "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 38 дугаар тогтоол

- Засгийн газрын 2016.05.31-ны өдрийн “Журам батлах тухай” 298 дугаар тогтоол
  - Засгийн газрын 2016.11.30-ны өдрийн “Журам батлах тухай” 169 дүгээр тогтоол
  - Засгийн газрын 2019.04.10-ны өдрийн “Журам батлах тухай” 138 дугаар тогтоол
  - Засгийн газрын 2020.06.12-ны өдрийн “Журам батлах тухай” 216 дугаар тогтоол
  - Засгийн газрын 2021.10.13-ны өдрийн “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” 314 дүгээр тогтоол
  - Барилга, хот байгуулалтын сайдын 2016.02.23-ны өдрийн “Журам батлах тухай” 28 дугаар тушаал
  - Барилга, хот байгуулалтын сайдын 2017.02.06-ны өдрийн “Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 25 дугаар тушаал
  - Барилга, хот байгуулалтын сайдын 2017.02.06-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 26 дугаар тушаал
  - Барилга, хот байгуулалтын сайдын 2020.05.15-ны өдрийн “Гэрээний загвар, өргөдлийн маягт батлах тухай” 90 дүгээр тушаал
  - “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2016.03.07-ны өдрийн “Төрийн түрээсийн орон сууцанд иргэдийг бүртгэх, сонгон шалгаруулах, түрээсийн орон сууцанд хамруулах ажлыг зохион байгуулах журам” А/21 тушаал
  - “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2017.03.31-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/45 тушаал
  - “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2017.05.18-ны өдрийн “Шинэчлэн батлагдсан түрээсийн төлбөрийг программд бүртгэж, түрээсийн орлогыг төвлөрүүлэх тухай” А/69 тушаал
  - “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020.07.07-ны өдрийн “Түрээсийн орон сууцанд иргэдийг сонгон шалгаруулах, түрээсийн орон сууцанд хамруулан өмчлүүлэх үйл ажиллагааны журам” А/111 тушаал
- “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020.07.20-ны өдрийн “Түрээсийн орон сууцыг өмчлөх, гэрээ байгуулах тухай” А/115 тушаал

### 3. 1520 ГЭРЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

Түрээсийн орон сууц хөтөлбөр нь:

1. Засгийн газрын 2015.06.15-ны өдрийн 248 дугаар тогтоолоор “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөрийн хүрээнд улсын төсөв, олон улсын

- байгууллага, хандивлагч орнуудын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр “Түрээсийн орон сууцны сан”-г бүрдүүлэх шийдвэр гаргасан.
2. Засгийн газрын 2016.01.11-ны өдрийн 38 дугаар тогтоолоор 929 орон сууц
  3. Засгийн газрын 2016.05.31-ны өдрийн 298 дугаар тогтоолоор 223 орон сууц
  4. Засгийн газрын 2016.11.30-ны өдрийн 169 дүгээр тогтоолоор 360 орон сууцнуудыг “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-д нийт 1512 орон сууцыг түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн.
  5. “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн Захирлын зөвлөлийн хурлын шийдвэрээр борлогдоогүй үлдсэн орон сууцнуудаас 8–г түрээсийн зориулалтаар шилжүүлсэн. Үүний үр дүнд 1520 орон сууцтай болсон.



**Түрээслүүлэх, түрээслээд өмчлөх, 100 хувь төлбөр төлсөн түрээсийн орон сууцны мэдээлэл**

*Хүснэгт 1*

№	Байршил	Нийт түрээсийн Орон сууц	Энгийн түрээс	Түрээслээд өмчлөх	100% төлбөр төлсөн
1	Буянт Ухаа 2	564	153	405	6
2	Хангай	223	132	90	1
Нийслэл нийт		787	285	495	7
3	Архангай	120	89	31	
4	Дархан	152	56	94	2
5	Сэлэнгэ	102	23	79	
6	Ховд	114	50	64	
7	Увс	105	40	65	
8	Хэнтий	140	49	91	
Орон нутаг нийт		733	307	424	2
Нийт		1520	592	919	9

Түрээслээд өмчлөх 919 гэрээг  
зорилтот бүлгээр ангилсан байдал

Хүснэгт 2

Байршил	Залуу гэр бүл	Төрийн албан хаагч	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Олон хүүхэдтэй гэр бүл	Өрх толгойлсон эцэг, эх	Ахмад настан	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнийг халамжилдаг гэр бүл	Байгалийн гамшгийн улмаас орон гэргүй болсон гэр бүл	Нийт
Буянт Ухаа-2	76	79	120	8	17	65	29	11	405
Хангай хотхон	20	16	17		5	21	7	4	90
<b>Нийслэл</b>	<b>96</b>	<b>95</b>	<b>137</b>	<b>8</b>	<b>22</b>	<b>86</b>	<b>36</b>	<b>15</b>	<b>495</b>
Хэнтий /А-15/	1	2	1						4
Ховд /Бугат/ Увс	12	20	14		1	14	2	1	64
/Галданбошигт/	11	23	9		3	16	3		65
Дархан /Нархан/	13	27	21		5	22	3	3	94
Сэлэнгэ /Ширхэнцэг мандал/	9	25	27		4	13	1		79
Хэнтий /ШӨХ/	2	47	12	1	1	12	1		76
Архангай /БХ/	2	8	8		2	7	3	1	31
Хэнтий /БӨ/	1	3	6			1			11
<b>Орон нутаг</b>	<b>51</b>	<b>155</b>	<b>98</b>	<b>1</b>	<b>16</b>	<b>84</b>	<b>13</b>	<b>5</b>	<b>424</b>
<b>Нийт</b>	<b>147</b>	<b>250</b>	<b>235</b>	<b>9</b>	<b>38</b>	<b>171</b>	<b>49</b>	<b>20</b>	<b>919</b>
Архангай /БХ/	1	2	2		1	2			8
<b>Орон нутаг</b>	<b>30</b>	<b>69</b>	<b>53</b>		<b>10</b>	<b>34</b>	<b>4</b>		<b>201</b>
<b>Нийт</b>	<b>71</b>	<b>111</b>	<b>122</b>		<b>19</b>	<b>77</b>	<b>21</b>		<b>433</b>

Түрээслээд өмчлөх 919 гэрээний урьдчилгаа 30% бүрдүүлэх,  
5 жилийн хугацааг дуусах оноор нь ангилсан байдал

Хүснэгт 3

Байршил	2025 он	2026 он	2027 он	2028 он	2029 он	2030 он
Буянт Ухаа-2	204	147	30	16	7	1
Хангай хотхон	28	44	7	7	3	1
<b>Нийслэл</b>	<b>232</b>	<b>191</b>	<b>37</b>	<b>23</b>	<b>10</b>	<b>2</b>
Хэнтий /А-15/	1		3			
Ховд /Бугат/ Увс /Галданбошигт/	31	15	2	12	2	2
Дархан /Нархан/	5	22	29	6	3	
Сэлэнгэ /Ширхэнцэг мандал/	67	18	2	3	4	
Хэнтий /ШӨХ/	65	8	2	4		
Архангай /БХ/	24	29	16	2	5	
Хэнтий /БӨ/	8	6	10	4	2	1
<b>Орон нутаг</b>	<b>201</b>	<b>107</b>	<b>65</b>	<b>32</b>	<b>16</b>	<b>3</b>
<b>Нийт</b>	<b>433</b>	<b>298</b>	<b>102</b>	<b>55</b>	<b>26</b>	<b>5</b>

Засгийн газрын 2015.06.15-ны өдрийн 248 дугаар тогтоолоор батлагдсан “Түрээсийн орон сууц” хөтөлбөрт хамрагдсан 592 иргэдийн түрээсийн гэрээний хугацаа хэтэрсэн мэдээлэл

Хүснэгт 4


Байршил	9 жил	8 жил	7 жил	6 жил	5 жил	4-өөс доош	Нийт
Буянт Ухаа-2	82	56	4	3	2	5	152
Хангай хотхон	31	91	2	1	2	5	132
<b>Нийслэл</b>							0
Хэнтий	2	37		2	1	7	49
Ховд	22	5		2	4	17	50
Увс	22	7	1	1	2	7	40
Дархан	24	23	3	5	1	24	80
Сэлэнгэ	16	1	2			4	23
Архангай	62		1			26	89
<b>Орон нутаг</b>							0
<b>Нийт</b>	<b>261</b>	<b>220</b>	<b>13</b>	<b>9</b>	<b>16</b>	<b>72</b>	<b>592</b>

Шууд борлуулагдсан түрээсийн орон сууцны мэдээлэл

Хүснэгт 5

№	Байршил	Тоот	Талбай	Өрөөний тоо
1	Хангай хотхон	514-01	41м2	2
2	Буянт Ухаа-2 хороолол	1007-49	68.59м2	3
3	Буянт Ухаа-2 хороолол	1007-41	49.23м2	2
4	Буянт Ухаа-2 хороолол	1009-15	39,3м2	2
5	Буянт Ухаа-2 хороолол	1009-40	39,3м2	2
6	Буянт Ухаа-2 хороолол	1010-5	49.23м2	2
7	Буянт Ухаа-2 хороолол	1010-31	68.59м2	3
8	Дархан-Уул аймаг, Наран хотхон	1-61	49.72м2	2
9	Дархан-Уул аймаг, Наран хотхон	Мэдээлэл олдохгүй		

Нийт түрээсийн болон түрээслээд өмчлөх гэрээ байгуулаан орон сууцад хамрагдсан зорилтот бүлгийн тоон мэдээллийг харуулав.



#### 4. Мөрдөгдөж байгаа журмын хүчинтэй, хүчингүй судалгаа

Төсөл хөтөлбөртэй холбогдуулан гарсан эрх зүйн актын үйлчлэх хүрээ, нөхцөл, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр, түүний хэрэгжилтийг хангуулах эрх бүхий албан тушаалтны тушаал зэрэгт шинжилгээ хийж хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа болон хүчингүйд тооцсон эрх зүйн актын судалгаа гарган, дүн шинжилгээ хийж ажиллаа.

2025 оны 07 дугаар сараас 9 дүгээр сар хүртэл түрээслүүлэх болон түрээслээд өмчлөх 1520 гэрээний хувийн хэрэгт дараах дэс дарааллын дагуу хийж гүйцэтгэлээ.

- Эхний ээлжид 8 сард гэрээний хугацаа дуусах 170 гэрээнд
- Буянт Ухаа-2 хороолол
- Хангай хотхон
- Орон нутаг

Шалгалт хийж илэрсэн алдаа зөрчлийг арилгуулахаар урьдчилсан байдлаар зөвлөгөө өгч гэрээ дүгнэн акт үйлдүүлэн илэрсэн алдаа зөрчилтэй холбоотой маргаанаар сонсох ажиллагаа явуулж цаашид авах арга хэмжээний талаар зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласаны үр дүнд эхний 170 гэрээнд гэрээ дүгнэсэн акт үйлдэж ажилласан. Гэрээ дүгнэх ажиллагаа үргэлжилж байгаа.

#### Хүснэгт 6 /Хүчинтэй эрх зүйн актууд/

Засгийн газрын тогтоол	Барилга, хот байгуулалтын яам	"Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК
2016.01.11-ны өдрийн "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 38 дугаар тогтоол	2020.05.15-ны өдрийн "Гэрээний загвар, өргөдлийн маягт батлах тухай" 90 дүгээр тушаал	2020.07.07 өдрийн "Түрээсийн орон сууцанд иргэдийг сонгон шалгаруулах, түрээсийн орон сууцанд хамруулан өмчлүүлэх үйл ажиллагааны журам" А/111
2016.11.30-ны өдрийн "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 169 дүгээр тогтоол		2020.07.20-ны өдрийн "Түрээсийн орон сууцыг өмчлөх гэрээ байгуулах тухай" А/115 тушаал
2016.05.31-ны өдрийн "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 298 дугаар тогтоол		
2019.04.10-ны өдрийн "Журам батлах тухай" 138 дугаар тогтоол		
2020.06.12-ны өдрийн "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" 216 дугаар тогтоол		
2021.10.13-ны өдрийн "Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай" 314 дүгээр тогтоол		

*Хүснэгт 7 /Хүчингүйд тооцсон эрх зүйн актууд/*

Засгийн газрын тогтоол	Барилга, хот байгуулалтын яам	"Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК
2015.06.15-ны өдрийн "Түрээсийн орон сууц" хөтөлбөр батлах тухай 248 тогтоол	2016.02.23-ны өдрийн "Журам батлах тухай" 28 дугаар тушаал	2016.03.07-ны өдрийн "Төрийн түрээсийн орон сууцанд иргэдийг бүртгэх, сонгон шалгаруулах, түрээсийн орон сууцанд хамруулах ажлыг зохион байгуулах журам" А/21 тушаал
	2017.02.06-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 26 дугаар тушаал	2017.03.31-ний өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" А/45 тушаал
	2017.02.06-ны өдрийн "Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 25 дугаар тушаал	2017.05.18-ны өдрийн "Шинэчлэн батлагдсан түрээсийн төлбөрийг программд бүртгэж, түрээсийн орлогыг төвлөрүүлэх тухай" А/69 тушаал


**5. Албан бичгээр гэрээ цуцлах тухай болон мэдэгдэл хүргүүлсэн тухай**

2017 оноос 2020 он хүртэл түрээслэх болон түрээслээд өмчлөх эрх авсан иргэдтэй байгуулсан гэрээг тушаалаар цуцалж байсан. Үүнд: 2017 онд 35, 2018 онд 31, 2019 онд 21, 2020 онд 68 тушаал гарч гэрээгээ цуцалсан баримт архивт байгаа боловч дээрх тушаалуудаар "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ны Гүйцэтгэх захирлын 2016.03.07-ны өдрийн А/21 дугаар журмын "Төрийн түрээсийн орон сууцанд иргэдийг бүртгэх, сонгон шалгаруулах, түрээсийн орон сууцанд хамруулах ажлыг зохион байгуулах журам"-ын 9 дүгээр зүйлд "түрээсийн орон сууцыг иргэнд хүлээлгэн өгөх, гэрээ дуусгавар болсны дараа буцаан хүлээн авах журам", "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ны 2020.07.07-ны өдрийн А/111 тушаалын 8.1 дэх хэсэгт заасныг мөрдсөн эсэх нь тодорхойгүй.

2020 оноос 2025 оны 9 дүгээр сар хүртэл гэрээг цуцалсан. Гэрээг цуцлах нь тушаалаар болон албан бичгээр гэж тусгайлан журамлаагүй болно. Үүнээс:

- 2020 онд албан бичгээр гэрээ цуцлах тухай 46
- 2021 онд албан бичгээр 133 мэдэгдэл, гэрээ цуцлах тухай 4
- 2022 онд албан бичгээр 62 мэдэгдэл, гэрээ цуцлах тухай 43
- 2023 онд албан бичгээр 18 мэдэгдэл, гэрээ цуцлах тухай 87
- 2024 онд 18 мэдэгдэл, 22 гэрээ цуцлах тухай
- 2025 онд 103 мэдэгдэл, 2 гэрээ цуцлах тухай албан бичгүүдээр хүргүүлж ажилласан.

## 6. Нийт 1520 гэрээний хэрэгжилт



## 7. Авлагын үлдэгдэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл /хотхон/ /2025 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар/

Хүснэгт 8

Байршил, хугацаа	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сараас дээш	Дүн
Буянт-Ухаа 2	116	56	25	14	1	13	225
Хангай хотхон	51	20	15	7	11	6	110
<b>Дүн</b>	<b>167</b>	<b>76</b>	<b>40</b>	<b>21</b>	<b>12</b>	<b>19</b>	<b>335</b>
Хэнтий А-15		3		1		2	6
Ховд /Бугат/	26	19	3	6	5	5	64
Увс /Галданбошигт/	24	11	7	12	8	7	69
Дархан /Нархан/	26	17	9	7	7	5	71
Сэлэнгэ /Ширхэнцэг мандал/	33	13	8	12	2	1	69
Хэнтий /ШӨХ/	25	12	7	4	3	13	64
Архангай /БХ/	32	13	8	7	6	8	74
Хэнтий /БӨ/	4	2	1	1		3	11
<b>Дүн</b>	<b>170</b>	<b>90</b>	<b>43</b>	<b>50</b>	<b>31</b>	<b>44</b>	<b>428</b>
<b>Бүгд дүн</b>	<b>337</b>	<b>166</b>	<b>83</b>	<b>71</b>	<b>43</b>	<b>63</b>	<b>763</b>

8. Авлагын үлдэгдэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл /аймаг, хотхон/  
/2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар/

Хүснэгт 9

Байршил	2025.09.24-ны байдлаар авлага	Залуу гэр бүл	Төрийн албан хаагч	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүл	Өрх толгойлсон эцэг, эх	Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмад настан	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнийг халамжилдаг гэр бүл	Гамшиг, аюулт үзэгдлийн улмаас орон гэргүй болсон иргэн
Буянт Ухаа 2	172,258,423	25,470,864	31,502,359	45,123,840	17,459,321	10,673,634	16,862,370	21,959,970	3,206,065
Хангай хотхон	67,459,884	13,346,726	6,327,845	17,354,596	0	5,532,141	13,036,783	6,688,961	5,172,832
Нийслэл Дүн	<b>239,718,307</b>	<b>38,817,590</b>	<b>37,830,204</b>	<b>62,478,436</b>	<b>17,459,321</b>	<b>16,205,775</b>	<b>29,899,153</b>	<b>28,648,931</b>	<b>8,378,897</b>
Архангай	42,029,467	4,635,000	11,988,757	7,228,513	975,000	2,449,701	9,902,490	1,085,006	3,765,000
Дархан	50,056,324	9,455,476	16,405,271	10,462,458	0	3,381,386	4,941,129	1,312,884	4,097,720
Сэлэнгэ	41,980,193	8,335,504	11,851,079	15,916,878	0	1,441,056	2,147,236	2,063,440	225,000
Ховд	50,107,462	17,946,035	16,139,631	8,254,032	900,000	748,090	4,874,672	1,245,000	0
Увс	68,753,015	12,200,004	31,644,443	4,251,439	960,000	1,694,285	17,970,368	32,476	0
Хэнтий	116,586,188	26,397,841	42,332,408	17,609,840	2,293,160	0	26,705,109	1,247,830	0
Орон нутаг Дүн	<b>369,512,649</b>	<b>78,969,860</b>	<b>130,361,589</b>	<b>63,723,160</b>	<b>5,128,160</b>	<b>9,714,518</b>	<b>66,541,004</b>	<b>6,986,636</b>	<b>8,087,720</b>
Нийт дүн	<b>609,230,956</b>	<b>117,787,450</b>	<b>168,191,793</b>	<b>126,201,596</b>	<b>22,587,481</b>	<b>25,920,293</b>	<b>96,440,157</b>	<b>35,635,567</b>	<b>16,466,617</b>

9. Илэрсэн зөрчлийг арилгуулах талаар хууль, хяналтын байгууллагад хандсан талаар

Компаний эрх бүхий албан тушаалтан нар нь албан үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа зорилтот бүлгийн иргэдэд олгогдох 13 орон сууцыг өөрийн хамаарал бүхий этгээдүүдэд олгосон.

Энэхүү зөрчлийг Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 1/1851 дугаар албан бичгээр ирүүлсэн илтгэх хуудасаар тогтоогдсон.

“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК -ийн 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн А/70 дугаар “Хяналт шалгалт явуулах тухай” тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн урьдчилсан дүгнэлтээр дээрх зөрчил арилаагүй байсан нь нотлогдсон тул “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК -ийн 2025 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн “Зөрчлийн мэдээлэл хүргүүлэх тухай” 1/811 албан бичгээр, хавсралт материалуудын хамт Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн шалгуулж байна.

10. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1. Засгийн газрын 2019 оны 138 дугаар тогтоолоор батлагдсан “Түрээсийн орон сууцыг өмчлөх журам”-ын 4.3-д “ ... бүрдэл дутуу материал хүлээн авахгүй”, 5.1-д “ ... материал зохих шаардлага хангаж байгаа эсэхийг хянах ...” заалтуудыг

хангалтгүй хэрэгжүүлсэн ба 5.2-д “ ... дэмжих, татгалзах шийдвэрийн аль нэгийг гаргана” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

2. Засгийн газрын 2019 оны 138 дугаар тогтоолоор батлагдсан “Түрээсийн орон сууцыг өмчлөх журам”-ын 2.1-д “Зохих шаардлагыг хангаж, түрээсийн орон сууцанд хамрагдсан зорилтот бүлгийн иргэн, эсхүл өрхийн бүртгэлд хамт бүртгэгдсэн гэр бүлийн гишүүн /цаашид “түрээслэгч” гэх/ түрээсийн орон сууцыг өмчлөх хүсэлт гаргана” гэж заасныг зөрчин түрээсийн орон сууцанд хамрагдаагүй иргэдэд шууд өмчлөхийн гэрээ байгуулсан Нийт 82 зөрчил илэрсэн. Журам зөрчин, бусдад давуу байдал олгон шууд өмчлөхийн гэрээ байгуулсан хугацааг авч үзэхэд: 2020 онд 60, 2021 онд 15, 2022 онд 5, 2023 онд 2 гэрээ байгуулсан байна.
3. Барилга хот байгуулалтын сайдын 2017 оны 26 дугаар тушаалаар батлагдсан “Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ын 2.2-д “Түрээсийн орон сууц хөтөлбөрийн хүрээнд бүрдүүлсэн төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцанд иргэдийг дараах ангилал, квот /хувь/-ын дагуу хамруулна” гэж заасныг мөрдөж ажлаагүй байна.

Батлагдсан квотыг одоо байгаатай нийслэл болон орон нутгаар харьцуулан доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 10

Байршил	ЗГБ		ТАХ		ХХЭ		ОХГБ		ӨТЭ		АН		ХБИ		БГ	
	Квот	Одоо	Квот	Одоо	Квот	Одоо	Квот	Одоо	Квот	Одоо	Квот	Одоо	Квот	Одоо	Квот	Одоо
Буянт Ухаа-2	113	105	141	108	113	165	28	9	28	30	85	87	28	39	28	15
Хангай	45	34	56	41	45	61	11	0	11	17	33	43	11	18	11	8
Тоо /ш/	158	139	197	149	158	226	39	9	39	47	118	130	39	57	39	23
Нийслэл %	20	17.7	25	18.9	20	28.7	5	1.1	5	6	15	16.5	5	7.2	5	2.9
Хэнтий	14	10	42	68	28	24	7	1	7	4	28	24	7	4	7	5
Ховд	11	18	35	34	22	23	6	1	6	2	22	30	6	6	6	2
Увс	11	13	32	33	21	14	5	1	5	6	21	34	5	4	5	0
Дархан	15	20	45	49	30	27	8	1	8	8	30	33	8	7	8	5
Сэлэнгэ	11	15	31	31	20	23	5	9	5	4	20	17	5	2	5	1
Архангай	12	14	36	35	24	22	6	1	6	7	24	27	6	9	6	5
Тоо /ш/	74	90	221	250	145	133	37	14	37	31	145	165	37	32	37	18
Орон нутаг %	10	12.3	30	34.1	20	18.1	5	1.9	5	4.2	20	22.5	5	4.4	5	2.5

4. Барилга хот байгуулалтын сайдын 2017 оны 26 дугаар тушаалаар батлагдсан “Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ын 6.1.1-

- д “Түрээсийн орон сууцанд хамрагдах хүсэлт ирүүлсэн иргэдийн баримт бичгийн бүрдлийг хянан шалгаж, шаардлага хангасан иргэдийг энэ журмын 5-д заасны дагуу эрэмбэлж сонгон шалгаруулалтыг зохион байгуулж орон сууцаар хангах” гэж заасныг хэрэгжүүлээгүй. 2017 оноос хойш зөрчил гаргасан 359 гэрээг цуцалсан. Энэхүү сул байгаа 359 орон сууцанд дараагийн иргэдийг хамруулахдаа **сонгон шалгаруулалт явуулалгүйгээр гэрээ байгуулсан зөрчил илэрсэн.**
5. “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны А/111 тушаалаар батлагдсан “Түрээсийн орон сууцанд иргэдийг сонгон шалгаруулах, түрээсийн орон сууцанд хамруулан өмчлүүлэх үйл ажиллагааны журам”-ын 3.3-д “үндсэн журмын 3.1-д заасан шалгуур үзүүлэлтээс гадна дараах нэмэлт шалгуур үзүүлэлтийг хангасан байна”, 3.3.2-д “Өмнө нь төрийн болон орон нутгийн түрээсийн орон сууц хөтөлбөрийн хүрээнд түрээсийн орон сууцанд хамрагдаагүй байх” гэж заасныг **хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй** байна. Учир нь гэрээ цуцалсан тушаал шийдвэр болон гэрээ, холбогдох материалыг архивт бүрэн хүлээлгэж өгөөгүй бөгөөд 2017 оноос хойш өнөөдрийг хүртэл цуцалсан гэрээ болон иргэдийн **дэлгэрэнгүй жагсаалтын сан** үүсгээгүй.
  6. “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны А/111 тушаалаар батлагдсан “Түрээсийн орон сууцанд иргэдийг сонгон шалгаруулах, түрээсийн орон сууцанд хамруулан өмчлүүлэх үйл ажиллагааны журам”-ын **8.1.3-д** “энэ журмын 8.1.2-т заасан актыг үндэслэн ашиглалтын асуудал хариуцсан нэгж орон сууцны ашиглалтын талаар дүгнэлт гаргаж, байрыг худалдан борлуулахад шаардагдах засвар шинэчлэлтийн тооцоог холбогдох газар хэлтэст хүргүүлэх ба амьдарсан хугацааны зардлыг Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 25 дугаар тушаалаар батлагдсан түрээсийн сарын төлбөрөөр тооц” гэж заасан боловч Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 90 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцыг өмчлөх гэрээ”-ний 2.9-д “Түрээслээд өмчлөгчийн буруутай үйл ажиллагаанаас болж гэрээ цуцалсан тохиолдолд барьцаа төлбөрийн баталгаа болон хуримтлагдсан урьдчилгаа төлбөрөөс гэрээний 2.1.6-д заасан түрээсийн төлбөрийг авч, үлдэгдэл төлбөрөөс энэ гэрээний 5.4-т заасан торгуулийг суутган авна” гэж заасан нь хоорондоо **зөрчилдөж** байна.
  7. Барилга хот байгуулалтын сайдын 2017 оны 25 дугаар тушаалаар түрээсийн орон сууцны 2017 онд мөрдөх 1м.кв талбайн түрээсийн төлбөрийг нийслэлд 6000 төгрөг, орон нутагт 4500 төгрөг байхаар шинэчлэн баталснаас хойш түрээсийн үнэнд өөрчлөлт ороогүй байна. Энэ нь ТӨБЗГ-ын 2020 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан төрийн өмчийн хөрөнгийг түрээслүүлэх төлбөрийн **доод хязгаарыг** түрээслэгчийн эрхэлж буй үйл ажиллагааны ангилал, салбарын

чиглэл зэргийг харгалзан “бусад ангилалаар нийслэлд 10 000 төгрөг, аймгийн төвд 5 000 төгрөг” гэж тогтоосноос доогуур байна.

Холбогдох журмуудыг хангалтгүй хэрэгжүүлсэн, мөрдөж ажиллаагүйн улмаас дээрх нийтлэг зөрчлүүд илэрч байна.

#### **Хангалтгүй хэрэгжүүлсэн:**

- Засгийн газрын 2019 оны 138 дугаар тогтоолоор батлагдсан “Түрээсийн орон сууцыг өмчлөх журам”-ын 4.3; 5.1
- Барилга хот байгуулалтын сайдын 2017 оны 26 дугаар тушаалаар батлагдсан “Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ын 2.2

#### **Хэрэгжүүлж ажилаагүй:**

- Засгийн газрын 2019 оны 138 дугаар тогтоолоор батлагдсан “Түрээсийн орон сууцыг өмчлөх журам”-ын 5.2
- Засгийн газрын 2019 оны 138 дугаар тогтоолоор батлагдсан “Түрээсийн орон сууцыг өмчлөх журам”-ын 2.1
- Барилга хот байгуулалтын сайдын 2017 оны 26 дугаар тушаалаар батлагдсан “Зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ын 6.1.1
- “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны А/111 тушаалаар батлагдсан “Түрээсийн орон сууцанд иргэдийг сонгон шалгаруулах, түрээсийн орон сууцанд хамруулан өмчлүүлэх үйл ажиллагааны журам”-ын 3.3

Иймээс Засгийн газрын 2021.10.13-ны өдрийн 314 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, холбогдох журмуудыг шинэчлэн батлуулж, үйл ажиллагаандаа мөрдөх шаардлагатай байна.

### **ЗӨВЛӨМЖ**

Ажлын хэсэг чиг үүргийн дагуу, удирдамжийн хүрээнд орон сууц түрээслэх болон түрээслээд өмчлөх гэрээ байгуулсан 1520 иргэний хувийн хэрэгт дотоод хяналт шалгалт хийж харьцуулсан график, хүснэгтээс харахад шийдвэрлэх шаардлагатай дараах асуудлууд байна. Үүнд:

1. Түрээсийн орон сууцны үнийн 30 хувийг 60 сарын хугацаанд тэнцүү дүнгээр хуваан төлж, үлдэгдэл 70 хувийг ипотекийн зээлд хамрагдах байдлаар төлж барагдуулах зохицуулалттай түрээслээд өмчлөх гэрээг байгуулсан 919 иргэнээс 433 иргэний гэрээний хугацаа дууссан ба үлдэгдэл төлбөрийг бүрэн төлөх санхүүгийн боломжгүй иргэдийн төлбөрийн асуудлыг цаашид хэрхэн

шийдвэрлэх нь тодорхойгүй; */Газрын дарга нараас санал авч ТУЗХ-аар шийдвэрлүүлэх/*

2. Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 25 дугаар тушаалаар түрээсийн 1м<sup>2</sup>-ийн үнийг нийслэлд 6,000 төгрөг, орон нутагт 4,500 төгрөгөөр тогтоож, дахин шинэчлэн тогтоогоогүй, зах зээлийн үнээс хэт доогуур үнээр түрээсийн гэрээг байгуулж байна. */Газрын дарга нараас санал авч ТУЗХ-аар шийдвэрлүүлэх/*
3. Түрээсийн гэрээ байгуулан 5-аас дээш жил орон сууц түрээсэлж байгаа 519 иргэн “Түрээслээд өмчлөх” гэрээ байгуулах хүсэлтээ удаа дараа илэрхийлж байгааг */Газрын дарга нараас санал авч ТУЗХ-аар шийдвэрлүүлэх/*
4. “Түрээслээд өмчлөх” гэрээг иргэдийн хүсэлтийн дагуу шийдвэрлэх нь түрээсийн орон сууцны хомсдол бий болгож, зорилтот бүлгийн иргэдийн эрэлт хэрэгцээг хангаж чадахгүйд хүрэх эрсдэлтэй байна.
5. Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор 2016 оны 248 дугаар тогтоолыг хүчингүй болгосон учир дагалдан гарсан журмууд хүчингүй болсон боловч дахин шинэчлэн гаргаагүй. Иймээс одоо мөрдөгдөж байгаа
  - ◆ Засгийн газрын 2019 оны 138 дугаар тогтоолоор батлагдсан “Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам”
  - ◆ “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ны гүйцэтгэх захирлын 2020 оны А/111 тушаалаар батлагдсан “Түрээсийн орон сууцанд иргэдийг сонгон шалгаруулах, түрээсийн орон сууцанд хамруулан өмчлүүлэх үйл ажиллагааны журам”
  - ◆ “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ны гүйцэтгэх захирлын 2020 оны А/115 тушаалаар батлагдсан “Түрээсийн орон сууцыг өмчлөх гэрээ байгуулах тухай” тушаал шийдвэрүүдийг нэгтгэн шинээр журам боловсруулан, Засгийн газраар батлуулах, эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх
6. Засгийн газрын 2021.10.13-ны өдрийн 314 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, журмуудыг шинэчлэн батлуулж, үйл ажиллагаандаа мөрдөх шаардлагатай байна. */Газрын дарга нараас санал авч ТУЗХ-аар шийдвэрлүүлэх/*
7. Түрээсийн болон түрээслээд өмчлөх гэрээнд хариуцлага тооцох, цуцлах, дуусгавар болгох заалтууд нь тодорхойгүй, шинэчлэх шаардлагатай. */Газрын дарга нараас санал авч ТУЗХ-аар шийдвэрлүүлэх/*

Жнь: Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 90 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцыг өмчлөх гэрээ”-ний 6.2.1 “Түрээслээд өмчлөгч гэрээний хавсралтад заасан төлбөрийн төлөлтийн хуваарийн дагуу төлөлтийг 3 сар дараалан төлөөгүй ...” гэрээ цуцална гэснийг өөрчлөх.

8. Гэрээний хэрэгжилтийг хангуулах үүднээс хяналт шалгалт явуулдаг ч тодорхой үр дүнд хүрч чаддаггүй: */Хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын дэмжлэг авах/*
9. Түрээсийн орон сууцанд хамрагдах иргэдийн сонгон шалгаруулалтын журмыг ил тод, нээлттэй, цахим хэлбэрт шилжүүлээгүйн улмаас үүдэн ашиг сонирхолын зөрчил үүсэх магадлал их байна.

10. Түрээсийн болоод түрээслээд өмчлөх гэрээг жил бүр дүгнэдэг байх. Гэрээг дүгнэхэд зөрчилтэй гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд хариуцлага хүлээлгэдэг байх. Гэрээний зөрчил гаргасан иргэдийн тусгай жагсаалт үүсгэх /программаас автоматаар устдаг тул дахин материал бүрдүүлж өгөхөд хамрагдах эрсдлээс сэргийлнэ/.
11. Түрээсийн орон сууцнаас 100 хувийн төлөлтөөр зарагдсан 9 ширхэг байрны хувийн хэргийн бүрдүүлэлтийг хийж “ОСЗТЦ-Систем” программд яаралтай мэдээллийг нөхөж оруулах
12. Засгийн газрын шийдвэрээр шилжиж ирсэн нийт 1512 түрээсийн орон сууцыг хаалганы дугаар, өрөөний тоо, талбайн хэмжээ тус бүрээр албажуулсан гүйцэтгэх захирлын тушаал гаргах
13. Нийт түрээслэгч өрхүүдийг даатгалд хамруулах, түрээсийн төлбөрөөс гадна эрсдлийн сан байгуулах
14. Хувийн хэргийн шалгах хүснэгт боловсруулж нийт хувийн хэргийг тогтсон дэс дараалалд оруулж цэгцлэх
15. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 1511 гэрээний хувийн хэргийг PDF файл болгон цахим сантай болох. Архивт хүлээлгэж өгөх, цаашид шинээр үүсэж буй хувийн хэрэг бүрийг цахим сантай болгон архивт хүлээлгэн өгч байх.
16. Түрээсийн орон сууцны 2026 онд мөрдөх 1м.кв талбайн түрээсийн төлбөрийг ТӨБЗГ-ын 2020 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан төрийн өмчийн хөрөнгийг түрээслүүлэх төлбөрийн доод хязгаар буюу нийслэлд 10 000 төгрөг, аймгийн төвд 5 000 төгрөгт нийцүүлэн шинэчилж батлан мөрдөх
17. Сонгон шалгаруулалтгүйгээр өмчлөх гэрээ байгуулсан 82 зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулах.
18. Эрсдлийн үнэлгээ болон санхүүгийн тооцоолол хийж цаашид түрээслээд өмчлөх болон энгийн түрээсийн аль хувилбар нь байгууллагад ашигтай болох ***/Газрын дарга нараас санал авч ТУЗХ-аар шийдвэрлүүлэх/***

#### **11. ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ НЭМЭГДҮҮЛЭХ ТАЛААР**

Түрээсийн орон сууцны үнийг өөрчлөх асуудал

1. Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 314-р тогтоол гарч “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хүчингүй болгосон. Энэ хүрээнд Хот Байгуулалт Барилга Орон Сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын эрх зүйн хэмжээнд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн түрээсийн төлбөрийг тогтоох асуудал нь үл хамаарах болсон.
2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т “Засгийн газраас тусгайлан журмалсанаас бусад үл хөдлөх хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг төрийн өмчит хуулийн этгээд эдлэнэ.” гэж заасанаар Түрээсийн орон сууцны үнийг “Төрийн орон сууцны кордарац” ТӨХХК нь бие даан шийдвэрлэх боломжтой.
3. Түрээсийн орон сууцны үнийг “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК нь өөрчлөхдөө Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газрын 2020 оны 49-р тогтоолыг удирдлага болгоно. ТӨБЗГ-ын 2020 оны 49-р тогтоолын хавсралт:

**Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн  
түрээсийн төлбөрийн доод хязгаар,  
түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар**


1. Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг түрээслүүэх төлбөрийн доод хязгаарыг түрээслэгчийн эрхэлж буй үйл ажиллагааны ангилал, салбарын чиглэл зэргийг харгалзан дараах байдлаар тогтооно.

*Хүснэгт 11*

№	Түрээслэгчийн эрхэлж буй үйл ажиллагааны ангилал, салбар, чиглэл, зориулалт	1 м2 талбайн түрээсийн төлбөрийн доод жишиг үнэ		
		Нийслэл	Аймгийн төв НД, БНД, БХД	Сумын төвд
1	Бусад	10000	5000	3000

2. Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй орон сууцыг хөлслөх тохиолдолд төлбөрийг тухайн хуулийн этгээд Иргэний хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тогтоож, гэрээ байгуулна.

**АЖЛЫН ХЭСЭГ:**

Дарга  
Хууль, эрх зүй, дотоод  
хяналтын газрын дарга  **Б.Лхамноржин**

Гишүүд:  
Хөрөнгийн ашиглалт,  
зохицуулалтын газрын дарга  **М.Цэвээн-Очир**

Хууль, хяналтын ахлах мэргэжилтэн  
Дотоод аудит хариуцсан мэргэжилтэн  **Э.Батсуурь**  
 **М.Анумарал**

Нарийн бичиг  
Хууль, эрх зүйн мэргэжилтэн  **А.Оюут**